



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.10.18 № 04/2008

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан НХААГ/20240101591 дугаартай "Сургуулийн барилга, 960 суудал (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо)"-ын ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсний дагуу тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Хариу
1.	Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.3 дахь заалт: "2020 онд гэрээ байгуулж уг гэрээгээ 2024 онд нэмэлт ажлын гэрээгээр шинэчлэн байгуулсан. 2024 оны комиссын акттай ажлыг ижил төстэй ажлын шалгуур шаардлагад дүйцүүлэн авч үзэх үү."	Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.3 дахь заалт: "Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх." гэж заасан. 2020 онд гэрээ байгуулж, мөн онд нэмэлт ажлын гэрээ шинэчлэн байгуулсан 2024 оны комиссын акттай ажлыг ижил төстэй ажилд тооцохгүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.